



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 14 өдөр

Дугаар А/178

Чингис хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.2, 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хэрэгжих Дулааны станцын ус хангамж ариутгах татуургын гадна шугам сүлжээний зураг төсөл боловсруулах ажлуудын зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга:	Л.Батсайхан	Орон нутгийн өмчийн газрын дарга
Нарийн бичгийн дарга:	Н.Үнэнбат	Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн
Гишүүд:	М.Хишигбаяр	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн
	Д.Оюун	Төрийн бус байгууллагын төлөөлөл
	Ж.Даваасүрэн	Төрийн бус байгууллагын төлөөлөл

2. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга /Л.Батсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231011741